



**Арилжааны мэдээ**

- Монголын хөрөнгийн бирж 2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс 2019 оны 6 дугаар сарын 07-ний өдрүүдэд 5 удаагийн үнэт цаасны арилжааг зохион байгуулж, өдөрт дунджаар 103 сая төгрөг буюу нийт 515,524,704.78 төгрөгийн арилжаа хийсэн байна.
- 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,342,470,955,341.37 төгрөг болсон бол “ТОП 20” индекс 19566.93 нэгж болж өмнөх долоо хоногоос 2.15%-аар буурсан үзүүлэлттэй байна.

**MSE Top 20 индекс**


Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

**Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа**


Эх сурвалж: Монгол Банк

**Тодруулга**

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.

**Зах зээлийн өөрчлөлт**

Индекс	Нэгж	% Өөрчлөлт
MSE Top-20 индекс	19566.93	2.15%
MSE A индекс	9045.31	3.11%
MSE B индекс	7843.67	0.45%

Зах зээлийн хураангуй	Нийт (MNT)
Зах зээлийн үнэлгээ	2,342,470,955,341.37
Арилжигдсан үнийн дүн	515 сая төгрөг

Үнийн дүнгээр	Хаалт (MNT)	Мөнгөн дүн
ЛЭНДМН ББСБ ХК	60.52	126,194,703.90
МОНОС ХҮНС	71.9	91,407,242.85
МАНДАЛ ДААТГАЛ	5055	70,104,185.00
АПУ	566	50,933,831.65
СТАНДАРТ НООС	280	42,734,720.00

Тоо ширхэгээр	Хаалт (MNT)	Нийт
ЛЭНДМН ББСБ ХК	60.52	2,078,034.00
МОНОС ХҮНС	71.9	1,273,372.00
СТАНДАРТ НООС	280	152,624.00
ТҮМЭН ШУВУУТ	160	112,051.00
ГОВЬ	282.75	102,834.00

Ханш өссөн	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
МОНГОЛ САВХИ	605.14	15.26%
АРИГ ГАЛ	3600	12.50%
ЖЕНКО ТУР БЮРО	71.5	8.32%
ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	108400	7.97%
МОНГОЛ БАЗАЛТ	289.97	7.40%

Ханш буурсан	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
ШИВЭЭ ОВОО	1600	-13.51%
ХЭРЛЭН ХИВС	68	-12.82%
СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	195	-11.36%
МИК ХОЛДИНГ	12500	-10.65%
МОНГОЛ ШЕВРО	2000	-10.19%

**ЭНЭ ДОЛОО ХОНОГ****“МОСТ ФИНТЕК” КОМПАНИ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО. (mse.mn)**

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/25 тоот тушаалаар “Мост Финтек” ХХК-ийн нийт 466,716,642 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн III ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцэж, 126 тоот тогтоолоор нийт гаргасан хувьцааны 22.23 хувь буюу 103,766,700 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд МХБ-ийн “Арилжааны журам”-ын дагуу тогтоосон үнийн аргаар санал болгон арилжаалахыг зөвшөөрлөө.

Санал болгон худалдах хувьцааны 11.12 хувь буюу 51.8 сая ширхгийг тус бүрийг нь 47 төгрөгөөр стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдсэн 11.12 хувь буюу 51.8 сая ширхгийг тус бүрийг нь 47 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдах замаар нийт 4.8 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

Тус компанийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээс давсан тохиолдолд нэмж 11.1 хувь буюу 51,649,942 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 47 төгрөгөөр худалдаалахыг зөвшөөрсөн байна.

Энэхүү хувьцааны андеррайтераар “Эс Жи Капитал ҮЦК” ХХК ажиллаж байгаа ба аудитын дүгнэлтийг “Хүлэгт Хүннү Аудит” ХХК, хууль зүйн дүгнэлтийг “Батбаяр энд Партнерс” ХХН, хөрөнгийн үнэлгээг “Координат Аудит” ХХК тус тус үзүүлсэн байна.

**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА 2019.06.10-НД ЭХЭЛНЭ. (mse.mn)**

СЗХ-ны даргын 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 1/2369 тоот албан тушаалаар “Инвескор ББСБ” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон тооцсон бөгөөд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байна.

Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсонтой холбогдуулан хөрөнгө оруулагчид үлдэгдэл мөнгөн хөрөнгийг өнөөдрөөс буцаан авах эрх үүслээ.

**“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН БҮРДЛЭЭ.” (frc.mn)**

БНСУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Райнос Ассет Менежмент Монгол” ХХК Монгол улсын үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулахаар нээлтээ хийв. Арга хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн нээж үг хэллээ. Тус компани нь Монгол улсад хөрөнгө оруулалтын менежмент, хөрөнгө оруулалтын сан байгуулан үйл ажиллагаагаа эрхэлж буй анхны гадаадын компани юм. Энэ үйл явдал нь сүүлийн жилүүдэд СЗХ-ноос санхүү, хөрөнгийн зах зээлд хэрэгжүүлсэн бодлого зөв байж, зах зээлийн тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжсэнийг, улмаар дотоод гадаадын хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөл бүрдэж эхэлснийг нотолсон үйл явдал боллоо.

БНСУ-ын “Rhinos Asset Management” компани 2017 онд Монголын Хөрөнгийн биржийн IPO-д хөрөнгө оруулсан анхны гадаад компани болж байлаа. Тэд “ЛэндМН” ХК-д 70 тэрбум төгрөгийн стратегийн хөрөнгө оруулалт хийж, Монголын санхүүгийн орчинд финтек технологид итгэл авчрах томоохон алхамыг эхлүүлсэн юм.

**ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН 7 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ҮНЭТ ЦААС ЗАХ ЗЭЭЛД ГАРЛАА**

Өнөөдөр Капитрон банк, Жи Мобайл ХХК-тай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хамтын ажиллагааг эхлүүлэх гэрээ байгууллаа. Гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн нээж үг хэллээ.

Санхүүгийн зохицуулах хороо 2018-2021 оны стратеги төлөвлөгөөндөө “Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, санхүүгийн зах зээлийг тэлэх” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Хорооны 2019 оны тавдугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар анхны арилжааны шинжтэй бүтцийн бүтээгдэхүүн болох “Жимобайл вексель” ТУЗ ХХК-д 7.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгосон.

Арилжааны банкуудаас хөрөнгийн зах зээлд оролцож, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж буй анхны банк нь “Капитрон банк” ХХК боллоо.

Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туршлагаас үзэхэд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаар дамжуулан орлогын дахин хуваарилалт хийж, иргэдийг орон сууцжуулах, хөрөнгийн зах зээлд хөрвөх чадвар сайтай, эрсдэлгүй бүтээгдэхүүнийг арилжаалдаг.

**ЛЭНДМН: ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР 4 САЯ ДОЛЛАР БОСГОНО. (marketinfo.mn)**

МХБ-ийн үнэт цаасны I ангилалд бүртгэлтэй Лэндмн ББСБ /MSE:LEND/ хувьцаат компани СЗХ-ноос Итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан талаар бид өмнө мэдээлж байсан билээ. Тэгвэл, тус компани нь “Мирэ Эссет Секьюритис Монгол” ҮЦК-тай 4 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг “Итгэлцлийн гэрээ”-ээр босгоход хамтран ажиллах санамж бичигт 2019.06.03-ны өдөр гарын үсэг зурлаа. Энэхүү хамтын ажиллагааны эхлэл болж 4-р сард “Мирэ Эссет Секьюритис Монгол” ҮЦК-аар дамжуулан эхний ээлжийн 1 сая ам.долларын санхүүжилтийг БНСУ-ын Райнос Эссет Менежмент болон бусад гадны хөрөнгө оруулагчдаас босгосон талаар компанийн зүгээс мэдээлэв. Энэ үеэр Лэндмн ББСБ /MSE:LEND/-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга “Манай компани 2019 онд өндөр зорилт тавьсан байгаа. Үүнд хүрэхэд бидний хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой” гэж онцолсон. Лэндмн ББСБ /MSE:LEND/-ийн хувьд энэ оны 1-р улиралд 78.9 тэрбум төгрөгийн зээлийг харилцагчиддаа олгож, 2.9 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан бөгөөд нэгж хувьцаандаа EPS = 1.56₮ буюу нийт 1.2 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олсон. Харин 2019 онд 6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар компани төлөвлөд байгаа юм.

**СТАНДАРТ НООС: ХУВЬЦААНЫ 50% НЬ 42.7 САЯ ТӨГРӨГӨӨР АРИЛЖИГДЛАА**

Өнөөдөр Стандарт ноос /MSE:ALI/ компанийн хувьцаан дээр томоохон хөдөлгөөн гарлаа. Тодруулбал, тус компанийн 152,624 ширхэг хувьцаа буюу 50% нь 42.7 сая төгрөгөөр арилжигдсан байна. Хувьцаа нэг бүр 280₮-ийн ханш дээр зарагдав.

Стандарт ноос /MSE:ALI/-ийн томоохон хувьцаа эзэмшигч нь Улаанбаатар хивс /MSE:UBH/ хувьцаат компани байдаг бөгөөд нийт хувьцааных нь 67.28%-ийг эзэмшдэг. Иймд энэхүү хөдөлгөөн тус компанитай холбоотой байгаа юм.



**О.Уранбайгаль**

Харилцагчийн албаны менежер  
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-7555-1919  
Факс: 976-11-321763

**Д.Шүрэнцэцэг**

Харилцагчийн алба, мэргэжилтэн  
И-мэйл: shurentsetsegd@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-7555-1919  
Факс: 976-11-321763

**С.Дөлгөөн**

Харилцагчийн алба, мэргэжилтэн  
И-мэйл: dulguun@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-7555-1919  
Факс: 976-11-321763

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.